



**“УЛААНБААТАР БҮК”ХК-ИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮД, ЭРХ БҮХИЙ АЛБАН
ТУШААЛТНУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ ЖУРАМ**

1. Ерөнхий зүйл

1. Энэхүү журмын зорилго нь ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын тухайн жилийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөхөд оршино.
2. ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын үнэлгээгээр дараах асуудлуудыг тодорхойлно:

- Тухайн жилийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж ТУЗ-ийн хороодын ажил, гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагааны давуу сул талыг тодорхойлох.
- ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын ажлын алдаа зөрчлийг арилгах.
- ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин хөлс, урмашууллын тогтолцооны үр ашгийг тодорхойлох.
- ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын сургах, хөгжүүлэх эрэлт хэрэгцээг тодорхойлох.
- ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудыг томилох, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх.

3. ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх ажлыг Нэр дэвшүүлэх хороо гүйцэтгэнэ.

2. Үнэлгээ өгөх журам

4. ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын тайлант жилийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх ажлыг 4 дүгээр сарын 1-ний дотор гүйцэтгэнэ.
5. ТУЗ-ийн гишүүд, болон ТУЗ-ийн үйл ажиллагаанд оролцдог ажлын албаны ажилтан, мэргэжилтнүүдийн ажлын үр дүнд Нэр дэвшүүлэх хороо, бусад эрх бүхий албан албан тушаалтнуудын ажлын үр дүн гүйцэтгэлд Гүйцэтгэх захирал үнэлгээ өгнө.
6. Үнэлгээний дүнг ТУЗ-ийн хаалттай хуралдаанаар хэлэлцээ танилцуулна.
7. Хуралдаанаар хороо бүрийн болон ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын гүйцэтгэсэн ажил, хангалтгүй гүйцэтгэсэн ажил, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, ажил сайжруулах арга замуудын талаар хэлэлцэнэ.
8. Үнэлгээгээр дараах асуудлуудыг эрчимжүүлэх, боловсонгүй болгох талаар хэлэлцэх бодлого барина:

- ТУЗ болон хороод, эрх бүхий албан тушаалтнуудын гүйцэтгэх үүрэг, роль
- ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын үүрэг
- ТУЗ болон хороодын, эрх бүхий албан тушаалтнуудын тэргүүлэх чиглэлийн ажлууд
- ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудад заавал байх мэдлэг, чадвар, туршлага, хувийн зан чанар.
- ТУЗ-ийн гүйцэтгэж буй ажлын явц, ялангуяа Хурлуудын бэлтгэл ажил, тасралтгүй тогтмол байдал, ТУЗ-ийг мэдээллээр хангах асуудал
- Хороодын үүрэг роль .

9. Үнэлгээ, дүгнэлт нь өнгөрсөн тайлант хугацааны үзүүлэлтүүдтэй харьцуулах зарчмыг агуулна.

3. ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээ

11. ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын үнэлгээг нэр дэвшүүлэх хороо нь Хавсралт 1-д заасан үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

4. Хууль эрх зүйн үндэслэл

12. Энэхүү журмыг батлах , өөрчлөлт оруулах асуудал нь ТУЗ-ийн эрх мэдлийн хүрээний асуудал байна.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Хавсралт

“ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

ТУЗ-ийн гишүүдэд дор дурдсан үзүүлэлтүүд тус бүрээр 1-5 оноо өгнө .

ТУЗ-ийн гишүүний овог нэр:

№	Үзүүлэлтүүд	Шалгуур, аргачлал	Үнэлгээ			
			Нийт авбал зохих үнэлгээ	Өөрийн үнэлгээ	Нэр дэвшүүлэх хорооны үнэлгээ	Хувь
1	ТУЗ-ийн хурлын оролцоо	Тухайн жилийн хурлын хуваарийн дагуу зохион байгуулсан хуралд оролцсон ирцийг үндэслэл болгоно	5			
2	"Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилт	СЗХ-оос өгсөн үнэлгээг харгалзана.	5			
3	ТУЗ-ийн хурлын идэвх	Хуралд оруулсан асуудлаар дэвшүүлсэн санал, тухайн жилд сургалтанд хамрагдсан байдлыг харгалзаж үнэлгээ өгнө.	5			
4	ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт	Тогтоол болон, хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын даалгаврын хэрэгжилтийг харгалзана	5			
5	ТУЗ-ийн дэргэдэх хороодод ажилласан байдал	Хороодын даргын үнэлгээг үндэслэнэ.	5			
6	ТУЗ-ийн гишүүдийн ёс зүй	Ес зүйн зөрчил гаргасан эсэхэд дүгнэлт гаргаж үнэлгээ өгнө.	5			
НИЙТ ОНОО			30			

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ

ТУЗ-ийн нөрийн бичгийн даргын ажлын үр дүнд дор дурдсан үзүүлэлтүүд тус бүрээр 1-5 оноо өгнө.

Нарийн бичгийн даргын овог нэр:

№	Үзүүлэлтүүд	Шалгуур, аргачлал	Үнэлгээ			
			Нийт авбал зохих үнэлгээ	Өөрийн үнэлгээ	Нэр дэвшүүлэх хорооны үнэлгээ	Хувь
1	ХЭХ, ТУЗ-ийн хурлуудын зохион байгуулалт	Тухайн жилийн хуваарааийн дагуух хурлуудын зохион байгуулалтыг харглзаж үнэлгээ дүгнэлт өгнө	5			
2	"Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилт	СЗХ-оос өгсөн үнэлгээг харгалзана.	5			
3	Тайлан мэдээллийн ил тод байдал	Хууль журамд заасан тайлан, мэдээллийг хугацаанд нь нийтэд тавьсан байдал	5			
4	ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт	Тогтоол болон, хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг харгалзана	5			
5	ТУЗ-ийн дэргэдэх хороодод ажилласан байдал	Хороодын даргын дүгнэлт үнэлгээг үндэслэнэ.	5			
6	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын гишүүдийн ёс зүй	Ес зүйн зөрчил гаргасан эсэхэд дүгнэлт өгнө.	5			
нийт оноо			30			

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ҮНЭЛГЭЭ

Эрх бүхий албан тушаалтнуудад дор дурдсан үзүүлэлтүүд тус бүрээр 1-5 оноо өгнө.

Эрх бүхий албан тушаалтны албан тушаал, овог нэр:

№	Үзүүлэлтүүд	Шалгуур, аргачлал	Үнэлгээ			
			Нийт авбал зохих үнэлгээ	Гүйцэтгэх захирлын үнэлгээ	Нэр дэвшүүлэх хорооны үнэлгээ	Хувь
1	Компанийн бизнес төлөвлөгөөний биелэлт	Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэд ТУЗ-ээс өгсөн дүгнэлтийг үндэслэл болгоно	5			
2	ХЭХ болон ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт	ХЭХ болон ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн гүйцэтгэлээр дүгнэнэ	5			
3	Засаглалын журмуудын хэрэгжилт	Засаглалын журмуудын биелэлтийн гүйцэтгэлээр үнэлгээ өгнө.	5			
4	Төрийн болон төрийн бус, хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагуудын үнэлгээ	хяналт шалгалтын байгууллагуудын дүгнэлтийг үндэслэл болгоно.	5			
5	Шинээр нэвтрүүлсэн ажил, үйлчилгээ	санхүү эдийн засгийн үзүүлэлтүүд өнгөрсөн жилийн үзүүлэлтийг харьцуулах, ахиц дэвшил гарсан байх эсэхэд үнэлгээ дүгнэлт өгнө.	5			
6	Эрх бүхий албан тушаалтнуудын ёс зүй	Ес зүйн зөрчил гаргасан эсэхэд үнэлгээ өгнө.	5			
НИЙТ ОНОО			30			